



# ДУНДГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



**ИРГЭДИЙН АЖИЛЛАЖ,  
АМЬДРАХ ОРЧИН НӨХЦӨЛИЙГ  
САЙЖРУУЛАХ ЖИЛ**

ГАЗАР НУТГИЙН ХЭМЖЭЭ:

**74 690** КВ.КМ





- Аймгийн ерөнхий мэдээлэл
- Хүн амын үндсэн үзүүлэлт
- Дотоодын нийт бүтээгдэхүүн
- ААНБ-ын тоон үзүүлэлт
- Эрүүл мэндийн зарим үзүүлэлт
- Ажил эрхлэлтийн зарим үзүүлэлт
- Засаг даргын мөрийн хөтөлбөр
- Боловсролын зарим үзүүлэлт
- Мал аж ахуйн зарим үзүүлэлт
- Аймгийн холбоотой ВЭБ хуудас



Дундговь аймаг нь 1941 онд Өмнөговь аймгаас 8 сум, Дорноговь аймгаас 3 сум, Төв аймгаас 7 сум тус тус шилжүүлэн 18 сумтайгаар одоогийн Өлзийт сумын нутаг Ембүү дэрсэнэ ус гэдэг газар Шарангад аймаг нэртэйгээр байгуулагджээ. 1942 онд аймгийн нэрийг Дундговь хэмээн өөрчилж аймгийн төв одоогийн оршин байгаа Зоогийн Хар овооны энгэрт суурьшсан байна.

Дундговь аймаг нь Засаг захиргааны хувьд 15 сум, 68 багтай ба урд талаараа Өмнөговь, баруун талаараа Өвөрхангай, хойд талаараа Төв, зүүн талаараа Говьсүмбэр, Дорноговь аймгуудтай тус тус хиллэн оршдог. Улаанбаатар хотоос 280 км зайтай, 74,7 мянган ам км нутаг дэвсгэртэй. Хүн амын дийлэнх хувийг халхчууд эзэлдэг. 2019 оны жилийн эцсийн байдлаар 46 437 хүн ам, 14 194 өрх, 14 121 хүүхэд багачууд амьдарч байна.



## Уур амьсгал

Аймгийн нутаг дэвсгэрийг уур амьсгалын хувьд хуурай, сэрүүн, уулын хээрийн муж /Эрдэнэдалайн хойд хэсэг, Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэнгийн хойд хэсэг/, нэн хуурай дулаавтар, цөлөрхөг хээрийн муж /Дэлгэрхангай, Хулд, Луус, Гурвансайхан, Өндөршил сумын хойд хэсэг, Сайхан-Овоо, Сайнцагаан, Говь-Угтаал, Цагаандэлгэр, Баянжаргалан сумдын нутаг/, нэн хуурай дулаан, цөлөрхөг хээрийн муж /Дэлгэрхангай, Хулд, Гурвансайхан сумдын урд хэсэг, Өлзийт сумын нутаг/ гэж 3 хуваадаг. Агаарын температурын дундаж хэмжээ өвлийн сард – 16-19 градус, зуны сард +17-21 градус, жилд орох хур тундасны хэмжээ 95-150 мм унадаг.





## Ёс заншил, өв уламжлал

Дуу хуур, гүүний айраг, хонины махны чанараараа улсдаа алдартай. Сайхан-Овоо сумын нутагт Өгөдэй хааны өвөлжөө, Буган чулуун хөшөө, Замбага хайрхан уулын хүннүгийн үеийн булш, дундад зууны үед холбогдох шаазан хотын туурь, Гурвансайхан сумын нутаг Ярх уулын хуучин чулуун зэвсгийн бууц суурин, дарханы газар хүрэл зэвсэг үйлдвэрлэлийн дурсгал, Дэлгэрхангай суманд Өгөдэй хааны нас эцэслэсэн газар, Адаацаг сумын Сүм хөх бүрдэд их хаадын намаржаа, Өлзийт сумын Дэл уулын хадны зураг, Дэлгэрийн Чойрын хийд, Эрдэнэдалай сумын сангийн далай хийдийн

Цогчин дугана, дөрвөлжин булш, хиргисүүрийн дурсгалууд эртний төрт улсуудын үед холбогдох булш бунхан эртний бэхлэлт цайз хэрэм зэрэг олон мянган жилийн турш хүмүүсийн аж төрж ирснийг илтгэх түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсээр нэн арвин.

Эртний далайн ёроолын үлдэц бүхий Цагаан суварга, Морин толгойн цав, Өөш манхан зэрэг өвөрмөц тогтоцтой байгалийн шавар цав элсэн манхан, Их газрын чулуу, Бага газрын чулуу зэрэг боржин чулуун уул, заг, хайлаасан төгөл, Олдох, Гурван төгрөг, Эргэнэг, Хаяа, Нэмнээ, Номгон, Хайрхан, Загийн ус зэрэг үзэсгэлэнт газруудтай.



## Нутгийн брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээ

Аймгийнхаа ард иргэдийн ахуй амьдралын хэвшил, уламжлал, байгалийн онцлог давуу тал, нөөц бололцоотой уялдуулан улсдаа “Дуу хуурын өлгий нутаг” хэмээн алдаршсан дуу хуур, эртний түүхэнд мөртэй үзэсгэлэнт Дундговь нутгийн аялал жуулчлал, гүүний айраг, ингэний хоормог, мах, хүрэн нүүрсний үйлдвэрлэлийг аймгийн брэндээр тодорхойлон бүс нутгийн төдийгүй улсын хэмжээнд эдгээр брэнд бүтээгдэхүүний үйлчилгээг бий болгож улмаар зарим бүтээгдэхүүнийг экспортод гаргах бодлого барин ажиллаж байна.





1.Засаглалын хүрээнд: Тогтвортой, хариуцлагатай, ил тод төрийн албыг төлөвшүүлнэ

2.Эдийн засгийн хүрээнд: Эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг сэйжруулан 21 аймгийн дундаас дээш төвшинд хүргэнэ

6. Бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын хүрээнд: Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг аймаг, сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тулгуурлаж, хүн ардын ая тухтай ажиллах, амьдрах нөхцөлийг сэйжруулахад чиглүүлнэ.

2016-2020 онд хөгжүүлэх Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр

3.Нийгмийн бодлогын хүрээнд: Иргэдийн эрүүл аюулгүй орчинд сурч хөгжих, ажиллаж амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн үйлчилгээнд тэгш хүртээмжтэй хамрагдах боломжийг бий болгох замаар хүний хөгжлийн хангаж, нийгмийн баталгааг нь сэйжруулна.

5. Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхайн хүрээнд: Байгалийн нөөцийг зохистой ашиглаж, нөхөн сэргээн аялал жуулчлал, уул уурхайгаас орон нутагт орох орлогын хэмжээг нэмэгдүүлнэ.

4. Хүнс, Хөдөө аж ахуй үйлдвэрлэлийн хүрээнд: Хүнс, хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангаж ажиллана.



## Бидний бахархал

Дундговь аймгийн бүтээлч, хөдөлмөрч, оюунлаг ард иргэдийн дотроос Улсын баатар 4, Хөдөлмөрийн баатар 17, Генерал 3, Ардын цолтон 10, Төрийн шагналт 7, гавъяат жүжигчин 31, бусад гавъяат цолтон 98, эрдэмтэн доктор 19, Улсын цолтой бөх 7, Улсын цолтой уяач 23, төрийн шагналт зохиолч 11 гараад байна.

### Биеийн тамир, спорт

- Биеийн тамир спортын байгууллага -1
  - Нийт ажиллагчид -13, Эмэгтэй -4
- Биеийн тамир, спортоор хичээллэгчид 17870
- Спорт заал -27
- Цол, зэрэгтэй тамирчид -1000
  - Дасгалжуулагчид 40, Эмэгтэй 10
  - ОУХМастер 1
  - Спортын мастер 18
  - Спортын дэд мастер 40
  - Цол зэрэгтэй шүүгчид 1, Эмэгтэй 1



## Биеийн тамир, спорт

- Дундговь аймгаас төрөн гарсан улсын цолтой бөхчүүд 7, спортын гавьяат цолтон 1, олон улсын хэмжээний мастер 7, спортын мастер 77, спортын дэд мастер 51, спортын зэрэг цолтон 1100, улсын шүүгч -1, зэрэгтэй шүүгч 38 байна.
- Олон улс, монголын бүх ард түмний спартакиад, хүүхдийн спортын наадам, улсын аварга шалгаруулах тэмцээнээс жилд 75-130 гаруй медаль хүртэж байна.





## Соёл, сүм хийд



- Мэргэжлийн урлагийн байгууллагын урын сан 128
- Мэргэжлийн урлагийн байгууллагын тоглолтын тоо 173
- Мэргэжлийн урлагийн байгууллагын үзэгчид 58800
- Нийтийн номын сан 15
- Нийтийн номын сангийн суудал 346
- Номын сангийн байнгын уншигчид 6237
- Сүм хийд 8
  - Будда 6
  - Христ 2





## Байгаль орчин

- Ойн сан бүхий газар 68.7 (мян.га)
  - Ойн модоор бүрхэгдсэн газар 27.1
  - Ой модыг огтолсон газар 0
  - Мод үржүүлгийн газар 10.3
  - Ой тэлэн ургах нөөц газар 33.0
  - Ойн сангийн бусад газар 0
- Гадаргын ус нийт гол горхи 1
  - Тасарсан 0
  - Ширгэсэн 0
- Рашаан нийт 4
- Булаг 125
  - Ширгэсэн 10
- Нуур, тойром 10
  - Ширгэсэн 0





## Тээвэр, харилцаа холбоо-2019 он

- Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан авто машин бүгд
  - 7821
- Суудлын авто машин
  - 4566
- Ачааны машин
  - 3043
- Автобус
  - 125
- Тусгай зориулалтын
  - 53
  - Ашигласан хугацаагаар:
    - 3 жил хүртэл 78
    - 4-9 жил 997
    - 10-аас дээш жил 6746





## Мөнгө, банк - 2019 он

- Нийт хадгаламжийн үлдэгдэл
  - 67 676.5 (сая.төг)
- Зээлийн өрийн үлдэгдэл
  - 116 441.5 (сая.төг)
- Чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл
  - 1267.2 (сая.төг)



## Төрийн санхүү - 2019 он

- Орон нутгийн төсвийн нийт орлого
  - 43 980.4 (сая.төг)
- Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг
  - 9 344.5 (сая.төг)
- Улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэг
  - 3 313.6 (сая.төг)
- Орон нутгийн төсвийн нийт зарлага
  - 44 241.2 (сая.төг)



## Хүн амын тоо, насны бүлгээр, 2019 он, сумдаар

Сумдын нэр	Нийт хүн ам	0-14	15-64	65+	Эрэмбэ
Дэлгэрцогт	1639	461	1073	105	
Дэрэн	2118	644	1350	124	
Говь-Угтаал	1542	436	1019	87	
Цагаандэлгэр	1017	294	667	56	XV хамгийн бага
Баянжаргалан	1261	403	784	74	
Өндөршил	1388	361	953	74	
Гурвансайхан	2140	580	1447	113	
Өлзийт	2360	648	1602	110	V
Хулд	2372	675	1574	123	IV
Луус	1863	532	1252	79	
Дэлгэрхангай	2292	711	1460	121	
Сайхан-Овоо	2111	603	1406	102	
Эрдэнэдалай	5806	1852	3641	313	II
Сайнцагаан	15716	5067	9791	858	I хамгийн их
Адаацаг	2812	854	1830	128	III
<b>Нийт</b>	<b>46437</b>	<b>14121</b>	<b>29849</b>	<b>2467</b>	



## Насны бүлгийн эзлэх хувь, хүйсийн харьцаа, 2019 он, сумдаар

Сумдын нэр	Нийт хүн амд хүүхдийн эзлэх хувь	Хөгшидийн эзлэх хувь	Хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь	Хүйсийн харьцаа	Эрэмбэ
Дэлгэрцогт	28.1	6.4	71.9	110.4	V
Дэрэн	30.4	5.9	69.6	105.0	
Говь-Угтаал	28.3	5.6	71.4	110.9	IV
Цагаандэлгэр	28.9	5.5	71.1	111.9	III
Баянжаргалан	32.0	5.9	68.0	114.5	II
Өндөршил	26.0	5.3	74.0	95.5	
Гурвансайхан	27.1	5.3	72.9	103.2	
Өлзийт	27.5	4.7	72.5	121.6	I хамгийн их
Хулд	28.5	5.2	71.5	105.0	
Луус	28.6	4.2	71.4	107.7	
Дэлгэрхангай	31.0	5.3	69.0	104.5	
Сайхан-Овоо	28.6	4.8	71.4	108.0	
Эрдэнэдалай	31.9	5.4	68.1	102.6	
Сайнцагаан	32.2	5.5	67.8	92.2	XV хамгийн бага
Адаацаг	30.4	4.6	69.6	105.6	
Нийт	30.4	5.3	69.6	101.6	

\*Хүйсийн харьцаа нь эрэгтэй хүн амын тоог эмэгтэй хүн амын тоонд харьцуулсан харьцаа бөгөөд энэ нь 100 эмэгтэйд ногдох эрчүүдийн тоог илэрхийлнэ.



## Хүн ам, сумаар 1995 – 2019 он

Сумдын нэр	1995	2000	2005	2010	2015	2018	2019	Эрэмбэ
Дэлгэрцогт	2554	2623	2251	1713	1575	1694	1639	
Дэрэн	2347	2530	2492	2213	2053	2105	2118	
Говь-Угтаал	1776	1906	1681	1598	1043	1586	1542	
Цагаандэлгэр	1668	1723	1343	1023	1013	1058	1017	XV хамгийн бага
Баянжаргалан	1515	1385	1213	1177	1197	1276	1261	
Өндөршил	1436	1508	1625	1548	1433	1421	1388	
Гурвансайхан	2448	2480	2726	2272	2098	2093	2140	
Өлзийт	2785	2967	2800	2389	2345	2363	2360	V
Хулд	2532	2631	2551	2274	2322	2416	2372	IV
Луус	2057	2232	2050	2047	1805	1864	1863	
Дэлгэрхангай	2681	2706	2506	2385	2177	2291	2292	
Сайхан-Овоо	2737	2715	2692	2537	2186	2156	2111	
Эрдэнэдалай	6662	7362	6712	6141	5690	5847	5806	II
Сайнцагаан	14450	13551	14090	13509	14602	15762	15716	I хамгийн их
Адаацаг	2863	3289	3202	3088	2847	2888	2812	III
Нийт	43551	51608	49934	45914	44926	46820	46437	




## Өрх, сумаар 2010 – 2019 он

Сумдын нэр	2010	2015	2017	2018	2019	ЭРЭМБЭ
Дэлгэрцогт	530	537	574	583	561	
Дэрэн	582	599	625	637	608	
Говь-Угтаал	512	536	541	537	496	
Цагаандэлгэр	366	383	390	397	398	XV Хамгийн баг
Баянжаргалан	419	413	412	443	454	
Өндөршил	464	467	479	487	466	
Гурвансайхан	654	655	678	684	658	
Өлзийт	689	800	849	863	752	IV
Хулд	655	689	731	742	717	V
Луус	542	544	561	579	562	
Дэлгэрхангай	668	652	710	718	671	
Сайхан-Овоо	688	645	670	692	660	
Эрдэнэдалай	1719	1679	1745	1766	1663	II
Сайнцагаан	3780	4477	4721	4868	4734	I Хамгийн их
Адаацаг	824	809	870	867	794	II
Нийт		13092	13885	14556	14194	




2019 онд монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 1.0 %, төвийн бүсийн 10.7% болох 381.0 тэрбум /урьдчилсан гүйцэтгэлээр/ төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 8.2 сая төгрөг, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 10.5 тэрбумд хүрсэн байна.





Амжиргааны доод түвшин онуудаар, бүсээр, төгрөгөөр






## БИЗНЕС РЕГИСТРИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО

Сумдын нэр	2015	2016	2017	2018	2019	Эрэмбэ
Сайнцагаан	463	494	535	583	607	I хамгийн их
Адаацаг	32	33	34	35	34	
Баянжаргалан	24	25	28	36	47	III
Говь-Угтаал	21	22	23	24	26	
Гурвансайхан	25	26	28	38	41	
Дэлгэрхангай	34	34	35	37	39	
Дэлгэрцогт	23	23	23	24	24	
Дэрэн	20	21	22	22	22	
Луус	18	20	21	28	34	
Өлзийт	30	31	32	35	40	
Өндөршил	35	38	41	42	46	VI
Сайхан-Овоо	33	35	36	36	38	
Хулд	37	38	39	45	45	V
Цагаандэлгэр	17	18	19	20	21	XV хамгийн бага
Эрдэнэдалай	49	49	49	52	54	II
Нийт	861	907	965	1057	1118	



## АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА – 2019 ОН



2019 оны жилийн эцсийн байдлаар Статистикийн хэлтсийн бизнес регистрийн санд нийт 1118 аж ахуй нэгж байгууллага байна. Үүнийг төрлөөр нь авч үзвэл: **71%** нь аж ахуйн нэгж, **16.5%** нь төрийн бус байгууллага, **12.5%** нь төсвийн байгууллага байна.



АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА –ын  
ажиллагчдын сарын дундаж цалин /2019.IV/



**799.900**

мянган төгрөг



**783.200** МЯН.ТӨГ



**811.700** МЯН.ТӨГ



## Эрүүл мэндийн зарим үзүүлэлт, 1995 – 2019 он

Үзүүлэлт	1995	2000	2005	2010	2015	2018	2019
Их эмч	93	101	81	88	123	137	153
Эм зүйч	6	6	4	2	12	14	15
Ердийн өсөлт (хүн)	811	744	482	822	1130	879	873
Нэг эмчид ногдох хүн	568	509	614	452	359	342	303
Нэг сувилагчид ногдох хүн	347	357	325	269	280	304	298
1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин	37.4	23.9	17.7	19.5	7.0	7.7	7.4
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	56.2	42.2	32.4	26.7	10.0	13.2	9.5
Үр хөндөлт	305	57	49	39	105	73	72
Халдварт өвчнөөр өвчлөгчид	389	387	160	287	989	407	407



## Төрөлт, нас баралтын тоо, жилийн эцсийн байдлаар, сумдаар

Сумдын нэр	Төрөлт		Нас баралт		Эрэмбэ
	2018	2019	2018	2019	
Дэлгэрцогт	48	24	14	10	
Дэрэн	52	67	11	10	IV
Говь-Угтаал	40	38	12	9	
Цагаандэлгэр	22	23	7	4	
Баянжаргалан	33	32	9	9	
Өндөршил	26	30	5	11	
Гурвансайхан	42	51	16	15	
Өлзийт	41	62	13	12	
Хулд	67	57	9	13	
Луус	57	36	16	15	
Дэлгэрхангай	68	64	25	21	V
Сайхан-Овоо	42	38	8	15	
Эрдэнэдалай	152	173	36	51	II
Сайнцагаан	438	416	111	95	I хамгийн их
Адаацаг	64	77	21	25	III
<b>Дүн</b>	<b>1192</b>	<b>1188</b>	<b>313</b>	<b>315</b>	



## Нийгмийн зарим үзүүлэлт, 1995 – 2018 он

Үзүүлэлт	1995	2000	2005	2010	2015	2018	2019
Төрөлт	1416	1214	905	974	1095	1192	1188
Эмэгтэй	702	606	439	461	491	571	570
Нас баралт	340	314	345	314	316	313	315
Бүтэн өнчин хүүхдийн тоо	59	51	57	58	32	36	35
Хагас өнчин хүүхдийн тоо	754	822	761	581	438	453	453
Өрх толгойлсон эхийн тоо	920	1445	1486	1820	1749	1913	2010
18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх	871	1014	1065	862	826	965	888
18 хүртэлх насны 4, түүнээс дээш хүүхэдтэй өрх	0	0	699	329	436	504	579



## Нийгмийн халамжийн үзүүлэлт 2019 он

Үзүүлэлт	2018	2019
Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан нийт хүн	15733	21088
-Алдарт эхийн одонтой эхчүүд	4576	4625
-0-3 насны хүүхэд асарсан эхчүүд	3080	3109
- Насны хишиг	2492	2565
-Жирэмсэн болон нярай хүүхэд асарсан эхчүүд	1431	1446
-Халамжийн тэтгэвэр авагчид	843	835
-Халамжийн тэтгэмж авагчид	993	1109
- Бусад	2318	7399



2018

1913

Өрх толгойлсон эхийн тоо

36

Бүтэн өнчин хүүхдийн тоо

453

Хагас өнчин хүүхдийн тоо

1070

Өрх үүсгэн ганц биеэр амьдардаг өндөр настан

2019



2010



35



453



1097




## Хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт 2014 – 2019 он

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018	2019
Хөдөлмөрийн насны хүн ам	29.5	29.8	30.1	30.5	30.5	30.5
Ажиллах хүч	22.1	21.2	22.2	23.7	24.5	23.2
Ажиллагчид	20.9	20.1	21.1	22.6	23.3	22.0
Ажилгүй иргэд	1144	1162	1133	1034	1218	1147
Эмэгтэй	358	467	377	325	584	847
Бүртгэлтэй ажилгүй иргэд	366	512	519	633	487	448
Эмэгтэй	187	281	293	307	264	224
Ажиллах хүчний оролцооны түвшин	74.9	73.1	73.7	77.7	79.6	78.4
Ажилгүйдлийн түвшин	5.2	5.5	5.1	4.4	5.0	4.9




### Ажлын байрны зуучлал /2015-2019/

- Ажлын байрны захиалга
- Ажлын байранд зуучлагдсан иргэд



### Аймгийн ажилгүйдлийн түвшин 2015-2019 он





## Боловсролын үзүүлэлт

Үзүүлэлт	2010/2011	2015/2016	2016/2017	2017/2018	2018/2019	2019/2020
ЕБСургуулийн тоо	18	19	19	19	19	19
ЕБС-д өдрийн ангид суралцагчдын тоо (1000 хүн)	8.4	7.9	8.1	8.1	8.0	8.3
ЕБС-ийн хамран сургалтын бохир жин (1-9 р анги)	88.4	91.7	94.1	95	91.5	93.7
ЕБС-ийн суралцагч-багшийн харьцаа	17.3	15.1	15.9	15.6	15.4	16
СӨБ-ийн байгууллагын тоо	20	22	21	21	21	22
СӨБ-д хамрагдсан хүүхдийн тоо (1000 хүүхэд)	3.2	3.1	3.2	3.3	3.3	3.4
СӨБ-д хамрагдалтын хувь	79.4	85.3	88	81	78.3	73.3




Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үндсэн багш 111


ЕБС-ийн 1 дүгээр ангид элсэгчид 927



Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдсан хүүхэд 3366



- ЕБС-д суралцагчдаас дотуур байранд суух хүсэлт гаргасан
- Амьдарч буй хүүхэд




ЕБС-д суралцаж байгаа малчин өрхийн хүүхэд




ЕБС-ийн үндсэн багш

Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчид





ЕБС, СӨБ-ийн байгууллагын тоо, сумдаар, 2019/2020 хичээлийн жилд





## Гэмт хэрэг-2019


- Бүртгэгдсэн гэмт хэрэг бүгд **211**
- Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг **60**
- Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг **9**
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг **111**
- Малын хулгайн гэмт хэрэг **29**
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг **16**
- Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагч **130**
  - Эмэгтэй **11**
  - 18 хүртэлх насны **20**
- Шүүхээр шийтгүүлсэн хүн **87**



# МАЛЫН ТОО, аймаг, нийслэлээр, мянган толгой



МОНГОЛЫН  
УЛСЫН  
СТАТИСТИК  
АГЫН



**НИЙТ МАЛЫН ТОО**


100.0 - 1 630.0
1 630.0 - 3 160.0
3 160.0 - 4 690.0
4 690.0 - 6 220.0



# МАЛЫН ТООГООР ТЭРГҮҮЛСЭН СУМ, мянган толгой



ᠮᠤᠯᠠᠨ ᠲᠡᠭᠦᠭᠦᠯᠰᠡᠨ ᠰᠤᠮᠤ





## Малын тоо

Малын төрөл	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Бодоор*	275,848	340,873	406,957	498,221	571,291	635,439	745,311	817,725	873,628
Толгойн тоо	1,348,686	1,671,946	1,996,261	2,435,193	2,764,373	3,059,855	3,592,978	3,825,941	4,093,121
Тэмээ	19,667	22,978	24,899	28,030	30,779	33,859	36,792	39,306	41,267
Адуу	59,692	71,979	84,983	105,145	123,695	137,024	160,153	162,902	178,172
Үхэр	21,029	27,574	35,596	45,926	54,948	62,672	75,277	76,119	78,170
Хонь	623,491	775,796	922,341	1,114,848	1,266,234	1,437,181	1,686,203	1,831,055	1,942,704
Ямаа	624,807	773,619	928,442	1,141,244	1,288,717	1,389,119	1,634,553	1,716,559	1,852,808

\*Бодод шилжүүлэхдээ адуу, үхрийг 1 бод, тэмээг 1.5 бод, 6 хонь 8 ямааг тус бүр 1 бод гэж тооцов. 2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр Дундговь аймгийн 15 сумын 68 багт 4.1 сая толгой мал тоолуулж 2018 оныхоос 267.2 мянган толгой малаар буюу 7.0 хувиар өссөн байна. Мал сүрэг таван төрөл дээрээ өссөн үзүүлэлттэй байна.




## Өрх, малчдын тоо, насны бүтэц, тэдний соёл, ахуйн байдал

Төрөл	2014	2015	2016	2017	2018	2019
Малтай өрх	7280	7503	7947	8283	8466	8593
Малчин өрх	5863	6181	6590	7001	7159	7248
Малчдын тоо	11214	11633	12171	12222	12136	12241
16-34 насны	3786	3868	3948	4021	3840	3661
35-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	6114	6426	6748	6337	6441	6690
Тэтгэврийн насны	1314	1339	1475	1864	1825	1882
Нийт малчдаас эмэгтэй	5203	5274	5485	5361	5210	5210
Насны бүрэлдэхүүн хувь	100	100	100	100	100	100
16-34 насны	33.8	33.3	32.4	32.9	31.7	29.9
35-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	54.5	55.2	55.4	51.8	53.2	54.7
Тэтгэврийн насны	11.7	11.5	12.1	15.3	15.1	15.4
Нийт малчдаас эмэгтэй хувь	46.4	45.3	45.1	43.9	42.9	42.6
Нэг малчин өрхөд ногдох малын тоо /толгойгоор/	415	447	464	513	534	564



## Малын тоо, сумдаар





## Мал сүргийн бүтэц, 2019 он, хувиар





2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр Дундговь аймгийн хэмжээнд 4 093 121 толгой мал тоологдсон байна.



41 267



178 172


1 942 704



78 170



1 852 808





## Хамгийн олон малтай сумд



Эрдэндалай 586 110

Сайнцагаан 417 540

Өлзийт 369 760


Гурвансайхан 313 220


Адаацаг 303 500








Малын төрлөөр нь авч үзвэл:













# ДУНДГОВЬ аймгийн 9 гайхамшиг

Дундговь аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 10 тоот тогтоолоор “ДУНДГОВЬ АЙМГИЙН ЕСӨН ГАЙХАМШИГ”-ийг тодруулан баталжээ.



# Дундговь аймагтай холбоотой ВЭБ хуудсууд

- <http://www.dundgovi.gov.mn>
- <http://www.dundgovi.nso.mn>